



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/70

Чингис хот

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2015 оны 330 дугаар тушаалаар баталсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2019 оны А/358 дугаар захирамжийн “1” дэх заалтаар үнэлгээний хорооны гишүүнээр томилогдон “Төрийн бус байгууллагын төлөөлөл” Т.Эрдэнэбаатарын худалдан авах ажиллагаанд оролцох гэрчилгээний хугацаа дууссан тул Ж.Даваасүрэн гэж өөрчлөлт оруулсугай.

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга /Л.Бат-Октябрь/-т даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

231010184